

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дүгэрсүрэн	Дугаар	L221
Оршин суугаа аймаг	Архангай	Оршин суугаа сум	Булган сум
Төрсөн газар	Булган сум	Төрсөн он	1933
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Бэйсийн хүрээ, Тусгалтын дуган	Сүм хийдийн дугаар	АРБГ 058, АРБГ057
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат



Архангай аймгийн Булган сумын Бэйсийн хүрээ, Тусгалтын дуган

За өнөөдөр 2007 оны 7-р сарын 3-ны өдөр манай баг судалгааны ажлаа Архангай аймгийн Булган сумаас үргэлжлүүлж байна. За тэгэхлээр Архангай Булган сум бол хуучнаар Сайнноён хан аймгийн Цэцэн Чин Вангийн хошууны энэ нутаг. Газар усныхаа байрлалаар бол Урд Тамир, алдарт Гурван Тамирын, Урд тамирын нутгаа.

Тэгэхлээр бид яг одоо энэ Булган сумын төвөөс зүүн урагшаа, бараг өмнөд тийшээ юмдаа, 10 орчим км байх, энэ хошуу нутгийн хурал номын томоохон газар байсан Бэйсийн хүрээний туурин дээрээс энэ ярилцлагыг хийж байна. Бэйсийн Хүрээний энэ туурь бол одоо энэ Хүрээний Тал гэдэг нэртэй газар энэ Урд Тамирын голын хойд эрэг, энэ өргөн уужуу дэнж дээр, Хонгорын овооны баруун өмнө талд, Баянцагаан уулын зүүн тал, Номтын уулс буюу Тамирын голын хойд эргээс хойш 100-гаад метр газар, 100 ч арай хүрэхгүйдээ, Хөх Эргийн Урд хэмээх энэ газар байрлаж байсан 1818 оны үед байгуулагдсан одоогоос бараг үндсэндээ 190-ээд жилийн түүхтэй ийм хурал номын газар байх юмаа. Ингээд энэ Бэйсийн хүрээний түүх, яагаад Бэйсийн хүрээ гэж нэрлэсэн бэ, энэ одоо хичнээн сүм дуганатай байсан, хэд орчим ламтай байсан энэ тухай бид нарт ярилцлага өгөхөөр яг энэ нутгийн унаган хүн эдүгээ Архангай амгийн төв Эрдэнэбулган сумын 1-р багт оршин суугаа, одоо 73-4ний нас

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

сүүдэр зооглож байгаа өндөр настан Дүгэрсүрэн гуай бидний ярианд оролцсон юм. Ингээд танаас сая асуусан хэдэн асуултынхаа дагуу хариулт өгнө үү гэж хүсье.

Дүгэрсүрэн:

Бэйсийн энэ хүрээ гэдэг нь 1918 оны үед Төргэрэлт хааны 23-аар оны Хаврын тэргүүн сарын 28-ны өдөр хийд нэрийг олсон байна. Энэ нь Бэйс Дондогдорж, Бэйс Балдорж нарын нэр бүхийн явуулсан, Бээжинд илгээсэн бичиг сэлтийн хариугаар бүрэлдэж тогтсон. энэ хийдийг байгуулахаар эзэн хаанд банди шавийн тоо, тэднийг захирах хүний эрх ямба, байгуулах газрыг дурьдан тамга олгохыг илгээж хийдийн нэр хишгийг гүйсан байна. Эд нарын хариуд бичиг ирж Далай Ламаас ирүүлсэн хариу нь, умард зүгийн Сайн ноён хаан аймгийн урд Тамираар нутагтай Бэйс Банжирлхүндэвийн хүүхдүүдийн байгуулж үүсгэсэн хийдийн нэрийг Хан орол тахитэгчилэн хэмээн нэрийг соёрхосон. Энэний нэг тамга надад, юу, энчээ нэг хүнд бий шүү хүү минь. Тиим энэ тамга нь. Тахитэгчилэн гэж. Энэ нэрийг эзэн хаанд уламжилсаны хариуд, 9 луутай, манж, монгол, төвд гурван хэл дээр бичигтэй эзэн хааны тамгыг дарсан ийм жа-д ирсний гадна, банди шавийн тоо 40, түүнийг даргалах **донч** 2, хийдийг даргалсан да лам зэргийг хамт зөвшөөрүүлэн ирүүлсэн байна. Энэ хийдийн эзэн болсон Банжирлхүндэвийн хүү Хамба Жамба Довдон Лхаарамба Жамба Балдиваа нар нь баруун зуу руу сургууль хийж ирээд энэ хийдийн хурал номыг удирдан зохион байгуулж эрдэм номыг заасан эрдэм чадалтай лам нар байсан гэж гарж байна. Ингээд болчихын биш юмуу? 40 ламтай 1918 оны үеэс үүсгэсэн бол 1938 оны үед 200 гаруй ламтай байж байгаад устсан. Энэ хүрээ хийд одоогоос урагш 150 жил болжээ. Энэ бол манай сумын нутагт бий болж өнгөрсөн түүх дурсгалт зүйлийн нэг юм.

04.33

Мөнхбат:

1918 гэж уншсан тийм, 1818 юм.

Дүгэрсүрэн:

Энэ дээр нэг залруулга хийгээдхэе. 1918 он гэдгийг би буруу хэлсэн байна. 1818 он юм байна шүү.

Мөнхбат:

За, баярлалаа. За тэгэхээр би ганцхан асуулт асууя. Та түрүүн ингэлээ тэр манжийн хаанаас ирсэн тамга энд хүнд хадгалагдаж байгаа гэсэн. Эртний хүрээ хийдүүд манжийн хаанаас зөвшөөрөл авдаг байсан юм шиг байгаа юм тиймээ? Энэ хүрээ хийдүүдийн түүхийг үзэж байхад тэгэхлээр энэ чинь одоогоор бол магадлан итгэмжлэгдсэн гэсэн үг юмаа даа. Энэнтэй та санал нийлэх үү?

Дүгэрсүрэн:

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэр Тахитэгчилэн хийдийн тамга гэсэн нэг тамга би үзсэн юм. За нэг дардас нь, хаа яваа бол, надад гэрт бий. Тэр тамга нь Булган сумын харъяат Эрдэнэбат гэж залууд байгаа юм. Хойно лам болсон хүн, одоо бие муутай байгаад байгаа, тэрүүнд байна уу, нэг бол одоо бид нартай нийлсэн энэ Лхамсүрэн хоёрын нэгэнд тэр тамга нь бий.

Мөнхбат:

За баярлалаа танд.